

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХЭНТИЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХЭА-2024/10/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2024 он
Цахим хуудас: www.open.audit.mn

Тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112
Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390
Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Еркегүл
Утас: 99040705
Цахим хаяг: erkhegulkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг khentii@audit.gov.mn хаягаар авна уу

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.02.23 № 197
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Э.ХОНГОРЗУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар авлага 3,229.8 сая төгрөг, өмнөх оны үр дүн 2,098.4 сая төгрөг, тайлант оны үр дүн 1,131.5 сая төгрөг байна.

Тайлант онд 2,282.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаанд 1,758.6 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 523.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгө, авлагыг чухалчлан авч үзэв.

Аудитаар байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайлан хэвлүүлэхээр 6.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө зарцуулсан боловч гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулаагүй, сэтгүүлээ хүлээж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зардалд хаасан, гарын авлага хэвлүүлэхээр урьдчилж төлсөн 5.4 сая төгрөгийг санхүүгийн тайланд урьдчилж төлсөн тооцоо дансаар бүртгээгүй байна.

232420210

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 29 зорилтын хүрээнд 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 99 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамаарахгүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,098,375,656.80</u>	<u>3,229,837,370.80</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	2,098,375,656.80	3,229,837,370.80
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	544,703,446.00
335	Бусад авлага	2,098,375,656.80	2,685,133,924.80
3351	Байгууллагаас авах авлага	-	5,400,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,098,375,656.80	2,679,733,924.80
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>-</u>	<u>-</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
393	Биет бус хөрөнгө	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,098,375,656.80</u>	<u>3,229,837,370.80</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,098,375,656.80</u>	<u>3,229,837,370.80</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,098,375,656.80	3,229,837,370.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	2,098,375,656.80	3,229,837,370.80
51210	Өмнөх үеийн үр дүн	2,098,375,656.80	2,098,375,656.80
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,131,461,714.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,098,375,656.80</u>	<u>3,229,837,370.80</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,364,027,000.00	2,305,217,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,167,287,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,167,287,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,167,287,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	940,425,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	113,501,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	1,113,361,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,364,027,000.00	137,930,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,364,027,000.00	137,930,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,359,827,000.00	137,930,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,200,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,708,296,595.20	1,173,755,286.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,708,296,595.20	1,173,755,286.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,700,000.00	84,452,204.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,700,000.00	84,452,204.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,700,000.00	84,452,204.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,705,596,595.20	1,089,303,082.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	511,044,800.00	395,881,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	511,044,800.00	395,881,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,194,551,795.20	693,421,382.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,194,551,795.20	693,421,382.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	655,730,404.80	1,131,461,714.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	655,730,404.80	1,131,461,714.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,364,027,000.00</u>	<u>2,305,217,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,167,287,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,167,287,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,167,287,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	940,425,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	113,501,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	1,113,361,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,364,027,000.00	137,930,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,364,027,000.00	137,930,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,359,827,000.00	137,930,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,200,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,994,296,595.20</u>	<u>2,995,858,732.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,994,296,595.20	2,995,858,732.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,700,000.00	89,852,204.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,700,000.00	89,852,204.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,700,000.00	89,852,204.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,991,596,595.20	2,906,006,528.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,797,044,800.00	1,667,881,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,797,044,800.00	1,667,881,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	544,703,446.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	544,703,446.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,194,551,795.20	693,421,382.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,194,551,795.20	693,421,382.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(630,269,595.20)</u>	<u>(690,641,732.00)</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	630,269,595.20	690,641,732.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	630,269,595.20	690,641,732.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>630,269,595.20</u>	<u>690,641,732.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,098,375,656.80	2,098,375,656.80
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,098,375,656.80	2,098,375,656.80
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,098,375,656.80	2,098,375,656.80
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,098,375,656.80	2,098,375,656.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,098,375,656.80	2,098,375,656.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,131,461,714.00	1,131,461,714.00
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	3,229,837,370.80	3,229,837,370.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,282,157,000.00	1,758,633,904.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,282,157,000.00	1,758,633,904.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	139,550,000.00	89,852,204.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	139,550,000.00	89,852,204.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	139,550,000.00	89,852,204.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,142,607,000.00	1,668,781,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,142,607,000.00	1,668,781,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,142,607,000.00	1,668,781,700.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,282,157,000.00	1,758,633,904.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,144,227,000.00	1,600,423,554.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	940,425,000.00	742,937,850.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,441,000.00	38,260,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,113,361,000.00	819,225,704.00
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	137,930,000.00	158,210,350.00
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	137,930,000.00	158,210,350.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,400.0 мянган төгрөгийн зөрчил илэрснийг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. Хөдөлмөрийн хууль, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн гарын авлага хэвлүүлэхээр урьдчилж төлсөн 5,400.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд урьдчилж төлсөн тооцоо дансаар бүртгээгүй зардалд хаасныг урьдчилж төлсөн зардлаар бүртгэж залруулав.

Аудитаар нийт 6,500.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

3.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайлангийн сэтгүүл хэвлүүлэхээр 6,500.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө зарцуулсан боловч гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулаагүй, сэтгүүлээ хүлээж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зардалд хаасан зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

3.3 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урьдчилгааг зардалд хаасан	1	5,400.0			1	5,400.0						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримгүй гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1	6,500.0	1	6,500.0								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс		
			Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Зөрчилгүй	0	0						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Зөрчилгүй	0	0						
Нийт дүн	0	0						